



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/319

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Алтай, Мянгад сумдад замын даацын хяналтын пүү байгуулах ажлын явцын хяналт хийх, пүүний байршил тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Балжинням – Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч

Н.Ирэхзаяа – “Автотээврийн төв” ТӨҮГ-ын дарга

Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын Авто замын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга: Ц.Сувдаа – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн.

2.Ховд аймгийн Алтай, Мянгад сумдад замын даацын хяналтын пүү байгуулах ажлын захиалагчийн хяналтын зардлаас шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3.Ховд аймгийн Алтай, Мянгад сумдад замын даацын хяналтын пүү байгуулах ажлын явцыг хянан баталгаажуулах, байршил тогтоох, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН